



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

137.	Газар хөдлөлтийг бүртгэх станц байгуулах тухай	Дугаар 01	329
138.	Өндөрлөг байршилд спортын бэлтгэлийн төв байгуулах тухай	Дугаар 02	330
139.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 03	331
140.	Журамд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 05	331
141.	Агентлаг байгуулах тухай	Дугаар 07	332
142.	Боомтын хөгжлийн загвар болон түүнд хамаарах давтан хэрэглэх зургийн жагсаалт батлах тухай	Дугаар 08	333

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

#### Газар хөдлөлтийг бүртгэх станц байгуулах тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-ыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Газар хөдлөлтийн гамшгийн аюулыг бууруулах судалгааны ажлыг эрчимжүүлэх, түүний идэвхжилийн төлөв байдал, хүчтэй голомтуудын горимыг судлах зорилгоор газар хөдлөлтийг бүртгэх байнгын ажиллагаатай станцыг Баянхонгор аймгийн Богд сум, Дундговь аймгийн Мандалговь, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод тус тус байгуулсугай.

2. Газар хөдлөлтийг бүртгэх станцын дүрэм, зохион байгуулалтын бүтцийг баталж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр, орон тооны жишиг хязгаарыг тогтоохыг Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.



3. Газар хөдлөлтийг бүртгэх станцуудын үйл ажиллагааны зардлыг улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД**

**Л.ГАНТӨМӨР**

### **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2014 оны 1 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 2

Улаанбаатар  
хот

#### **Өндөрлөг байршилд спортын бэлтгэлийн төв байгуулах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Спортын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Улаанбаатар хот орчимд далайн төвшнөөс 1450 метрээс дээш, аймаг, орон нутагт 1500-2200 метрийн өндөрлөг байршилд дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар спортын бэлтгэлийн төв байгуулахыг дэмжсүгэй.

2. Спортын бэлтгэлийн төв байгуулах тохиромжтой байршлуудыг орон нутгийн хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд тусган газар олгож, дэмжин ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Завхан аймгийн Отгон суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар спортын бэлтгэлийн төв байгуулах талаар санал боловсруулж Засгийн газарт танилцуулахыг Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэлд даалгасугай.

4. Тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд хамаарах байршилд хууль тогтоомжийн хүрээнд зөвшөөрөл олгохыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюунд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Ц.ОЮУНГЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 1 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 3

Улаанбаатар  
хот

### Хөтөлбөр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2013 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр Улаанбаатар хотод гарын үсэг зурсан “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын 2013-2016 оны Соёл, боловсрол, шинжлэх ухааны солилцооны хөтөлбөр”-ийг баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Ц.ОЮУНГЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 1 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 5

Улаанбаатар  
хот

### Журамд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Журам батлах тухай” Засгийн газрын 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 70 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Улсын сайн малчин шалгаруулах журам”-ын 2 болон 10 дугаар зүйлийн “15 хүртэлх” гэснийг “53 хүртэлх” гэж, мөн тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Улсын тэргүүний тариаланч хамт олон, улсын тэргүүний тариаланч шалгаруулах журам”-ын 2 дугаар зүйлийн “8 хүртэл аж ахуйн нэгж, байгууллагыг сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтийг үндэслэн “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, 15 хүртэл иргэнийг сүүлийн 3 жилийн” гэснийг “10 хүртэл аж ахуйн нэгж, байгууллагыг сүүлийн 6 жилийн ажлын үзүүлэлтийг үндэслэн “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, 18 хүртэл иргэнийг сүүлийн 6 жилийн” гэж, мөн журмын 10 дугаар зүйлийн “8 хүртэл” гэснийг “10 хүртэл” гэж, “15 хүртэл” гэснийг “18 хүртэл” гэж тус тус өөрчилсүгэй.



2. “Журам батлах тухай” Засгийн газрын 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 70 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Улсын сайн малчин шалгаруулах журам”-ын 13 дугаар зүйлийн “2.0 (хоёр) сая” гэснийг “3.0 (гурван) сая” гэж, мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Улсын тэргүүний малчдын бүлэг шалгаруулах журам”-ын 12 дугаар зүйлийн “3.0 (гурван) сая” гэснийг “5.0 (таван) сая” гэж, мөн тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Улсын тэргүүний фермер шалгаруулах журам”-ын 13 дугаар зүйлийн “3.0 (гурван) сая” гэснийг “5.0 (таван) сая” гэж, мөн тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Улсын тэргүүний тариаланч хамт олон, улсын тэргүүний тариаланч шалгаруулах журам”-ын 12 дугаар зүйлийн “5.0 (таван) сая” гэснийг “10.0 (арван) сая” гэж, мөн зүйлийн “1.0 (нэг) сая” гэснийг “3.0 (гурван) сая” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ  
АЖ АХУЙН САЙД**

**Х.БАТТУЛГА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 1 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 7

Улаанбаатар  
хот

### Агентлаг байгуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup>.1, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1, 6.3, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Улсын Их Хурлын 2012 оны 14 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 67 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Тахарын ерөнхий газрыг байгуулсугай.

2. Дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хууль зүйн сайд Х.Тэмүүжинд даалгасугай:

2.1. Тахарын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги бүтцийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг баталж мөрдүүлэх;

2.2. Тахарын ерөнхий газрыг үйл ажиллагаа явуулах ажлын байраар хангах.



3. Тахарын ерөнхий газрын төсвийг Хууль зүйн сайдын 2014 оны багцад батлагдсан төсвөөс шийдвэрлэхийг Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 6 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн жагсаалт”-ын “Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал” гэсний дор “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд” гэсэн хэсгийн “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн баганад “9<sup>1</sup>. Тахарын ерөнхий газар” гэж нэмсүгэй.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Засгийн газрын агентлагийн орон тоо батлах тухай” Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 43 дугаар тогтоолд дор дурьдсан нэмэлт оруулсугай.

№	Агентлагийн нэр	Орон тоо
24	Тахарын ерөнхий газар	178

6. Энэ тогтоолыг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**ХУУЛЬ ЗҮЙН САЙД**

**Х.ТЭМҮҮЖИН**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2014 оны 1 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 8

Улаанбаатар  
хот

**Боомтын хөгжлийн загвар болон түүнд  
хамаарах давтан хэрэглэх зургийн  
жагсаалт батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Боомтын хөгжлийн загвар”-ыг 1 дүгээр хавсралт ёсоор, “Боомтын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих барилга,



байгууламжийн давтан хэрэглэх зургийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. “Боомтын хөгжлийн загвар”-ыг хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, улсын хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр боловсруулахад баримталж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан нарт даалгасугай.

3. Боомтын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих барилга, байгууламжийн давтан хэрэглэх зураг төслийг боловсруулах зургийн даалгаврыг 2014 оны 1 дүгээр улиралд багтаан боловсруулахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайханд даалгасугай.

4. Давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах зардлыг 2014 оны Улсын төсвийн тодотголд тусгаж, 4 дүгээр улиралд багтаан боловсруулж дуусган, хөрөнгө оруулалтын бодлоготой уялдуулан хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**ЭДИЙН ЗАСГИЙН  
ХӨГЖЛИЙН САЙД**

**Н.БАТБАЯР**

Засгийн газрын 2014 оны 8 дугаар тогтоолын  
1 дүгээр хавсралтын 1 дүгээр хэсэг

**БООМТЫН ХӨГЖЛИЙН ЗАГВАР**

I. Олон улсын зорчигч, ачаа тээврийн, байнгын ажиллагаатай боомтууд					
д.д	Барилга, байгууламжийн нэр	Хүчин чадал		Барилга, байгууламжийн тоо	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
		хэмжих нэгж	хэмжээ		
1. Хяналт шалгалтын бүс					
1.1 Авто замын шалган нэвтрүүлэх бүсийн барилга, байгууламж					



1	Хилийн хаалга	м	20	1	Улсын төсөв
2	Хилийн шалганы байр	м <sup>2</sup>	36	4	
3	Шалган нэвтрүүлэх цогцолбор (доороо гражтай)	м <sup>2</sup>	2300	1	
4	Түр саатуулах машины граж	м <sup>2</sup>	72	1	
5	Авто пүү	тн	150	4	
6	Эрэлч нохойн байр	м <sup>2</sup>	100	1	
7	Мал, амьтанд эрүүл мэндийн үзлэг хийх байр	м <sup>2</sup>	45	1	
8	Хяналтын цамхаг	өндөр	стандарт	1	
9	Нийтийн бие засах газар	м <sup>2</sup>	9.6	2	Орон нутгийн төсөв
1.1.1 Хилийн цэргийн албаны барилга, байгууламж					
10	Шалган нэвтрүүлэх заставын албаны байр	м <sup>2</sup>	50	1	Улсын төсөв
11	Гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчдын байр	м <sup>2</sup>	350	1	
12	Автомашинны граж	м <sup>2</sup>	18	4	
13	Агуулах	м <sup>2</sup>	216	1	
14	Албаны зочид буудал	м <sup>2</sup>	360	1	
15	Жижүүр харуулын байр	м <sup>2</sup>	18	1	
1.2 Төмөр замын шалган нэвтрүүлэх бүсийн барилга, байгууламж					
16	Төмөр замын шалган нэвтрүүлэх цогцолбор	м <sup>2</sup>	3450	1	Улсын төсөв
2. Логистикийн бүс					
2.1 Гаалийн хяналтын бүс					
17	Гаалийн хяналтын албаны байр	м <sup>2</sup>	1500	1	Хувийн хөрөнгө оруулалт
18	Лаборатори /Мэргэжлийн хяналтын/	м <sup>2</sup>	1900	1	
19	Лаборатори /Барилгын материалын/	м <sup>2</sup>	1200	1	
2.2 Агуулах, хадгалалтын бүс					
20	Химийн болон тэсэрч дэлбэрэх бодис хадгалах агуулах	м <sup>2</sup>	1800	1	Хувийн хөрөнгө оруулалт
21	Хүнсний бүтээгдэхүүний агуулах	м <sup>2</sup>	1800	4	
22	Хөргөлттэй агуулах	м <sup>2</sup>	1800	2	
23	Дулаан агуулах	м <sup>2</sup>	1800	4	



2.3 Ачаа тээвэр, терминалын бүс					
24	Том оврын техник хэрэгслийн агуулах	м <sup>2</sup>	1800	2	Хувийн хөрөнгө оруулалт
25	Задгай агуулах	м <sup>2</sup>	1800	4	
2.4 Бизнесийн төв					
26	Бизнес мэдээлэл сурталчилгаа, үйлчилгээний төв	м <sup>2</sup>	4800	1	Хувийн хөрөнгө оруулалт
27	Олон улсын тээвэр зуучлалын албаны байр	м <sup>2</sup>	3400	1	
28	Зочид буудал	м <sup>2</sup>	5500	1	
29	Үзэсгэлэн худалдаа	м <sup>2</sup>	4000	2	
30	Оффис	м <sup>2</sup>	3000	1	
31	Агуулах	м <sup>2</sup>	1800	4	
32	Жижиг дунд үйлдвэрийн барилга, байгууламж	м <sup>2</sup>	500	4	
33	Хог ангилан, анхан шатны боловсруулалт хийх байгууламж	м <sup>2</sup>	1000	1	
3. Суурьшлын бүс					
34	Доороо үйлчилгээтэй нийтийн орон сууц	м <sup>2</sup>	2200	28	Улсын төсөв, Хувийн хөрөнгө оруулалт
35	Эдэлбэр газартай амины орон сууц	м <sup>2</sup>	384	36	
36	Эдэлбэр газаргүй амины орон сууц	м <sup>2</sup>	340	30	
37	Сургууль (480 суудалтай)	м <sup>2</sup>	5000	1	Улсын төсөв
38	Цэцэрлэг (75 хүүхдийн)	м <sup>2</sup>	620	1	
39	Эрүүл мэндийн төв (10 ортой)	м <sup>2</sup>	585	1	
40	Соёл, спортын цогцолбор (240 суудал)	м <sup>2</sup>	1500	1	
41	Засаг захиргааны барилга	м <sup>2</sup>	700	1	
42	Худалдаа, үйлчилгээний төв (банк, холбооны салбартай)	м <sup>2</sup>	1000	2	Хувийн хөрөнгө оруулалт
43	Оффис	м <sup>2</sup>	6500	1	
44	Цагдаагийн хэсэг	м <sup>2</sup>	190	1	Улсын төсөв





Зам талбай, ногоон байгууламж					
1	Хорооллын чанартай төв зам (өргөн 10-12м)	км	10	Орон нутгийн төсөв	
2	Хороолол доторх зам (өргөн 5-7.5 м)	км	14		
3	Амралт, спорт, явган хүний зам талбай	мян.м <sup>2</sup>	65		
4	Нийтийн хэрэгцээний ногоон байгууламж	мян.м <sup>2</sup>	44		
5	Тусгай зориулалтын ногоон байгууламж	мян.м <sup>2</sup>	20		
Инженерийн дэд бүтэц					
Д.д	Инженерийн хангамж	Эх үүсвэр, шугам сүлжээний нэр, хүчин чадал		тоо, хэмжээ	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	Цахилгаан хангамж	дэд станц (35/10кВ)		3	Улсын төсөв
		ЦДАШ (35кВ) (км)		15	
2	Дулаан хангамж	зуух (1МВт)		6	
		гол шугам (ф273) (км)		20	
		хэрэгцээний халуун усны шугам (ф133x2) (км)		8	
3	Ус хангамж	усан сан (м.куб/хоног)		500	
		гүний худаг		3	
		гол шугам (ф200) (км)		20	
4	Ариутгах татуурга	цэвэрлэх байгууламж (м.куб/хоног)		1000	
		өргөлтийн насос станц		2	
		гол шугам (ф350)		20	
5	Холбоо	Цамхаг		1	
		АТС-ын шугам сүлжээ		25	
Боомтын нэвтрүүлэх хүчин чадал					
Зорчигч, ачаа тээврийн боомт	Үзүүлэлт			Хэмжээ	
	Зорчигч (хүн/хоног)			4000	
	Суудлын автомашин (машин/хоног)			600	
	Том оврын тээврийн хэрэгсэл (машин/хоног)			300	
Уул уурхайн бүтээгдэхүүн, зорчигч, ачаа тээврийн боомт	Зорчигч (хүн/хоног)			4000	
	Суудлын автомашин (машин/хоног)			200	
	Том оврын тээврийн хэрэгсэл (машин/хоног)			500	



Засгийн газрын 2014 оны 8 дугаар тогтоолын  
1 дүгээр хавсралтын 2 дугаар хэсэг

II. Хоёр талын зорчигч, ачаа тээврийн, байнгын ажиллагаатай боомтууд					
д.д	Барилга, байгууламжийн нэр	Хүчин чадал		Барилга, байгууламжийн тоо	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
		хэмжих нэгж	хэмжээ		
1. Хяналт шалгалтын бүс					
1.1 Авто замын шалган нэвтрүүлэх бүсийн барилга, байгууламж					
1	Хилийн хаалга	м	20	1	Улсын төсөв
2	Хилийн шалганы байр	м <sup>2</sup>	36	2	
3	Шалган нэвтрүүлэх цогцолбор (доороо гражтай)	м <sup>2</sup>	1800	1	
4	Түр саатуулах машины граж	м <sup>2</sup>	72	1	
5	Авто пүү	тн	150	2	
6	Эрэлч нохойн байр	м <sup>2</sup>	100	1	
7	Мал, амьтанд эрүүл мэндийн үзлэг хийх байр	м <sup>2</sup>	45	1	
8	Хяналтын цамхаг	өндөр	стандарт	1	
9	Нийтийн бие засах газар	м <sup>2</sup>	9.6	2	Орон нутгийн төсөв
1.1.1 Хилийн цэргийн албаны барилга, байгууламж					
10	Шалган нэвтрүүлэх заставын албаны байр	м <sup>2</sup>	50	1	Улсын төсөв
11	Гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчдын байр	м <sup>2</sup>	350	1	
12	Автомашини граж	м <sup>2</sup>	18	4	
13	Агуулах	м <sup>2</sup>	216	1	
14	Албаны зочид буудал	м <sup>2</sup>	360	1	
15	Жижүүр харуулын байр	м <sup>2</sup>	18	1	
1.2 Төмөр замын шалган нэвтрүүлэх бүсийн барилга, байгууламж					
16	Төмөр замын шалган нэвтрүүлэх цогцолбор	м <sup>2</sup>	3450	1	Улсын төсөв
2. Логистикийн бүс					
2.1 Гаалийн хяналтын бүс					
17	Гаалийн хяналтын албаны байр	м <sup>2</sup>	1000	1	Хувийн хөрөнгө оруулалт
18	Лаборатори (Мэргэжлийн хяналтын)	м <sup>2</sup>	1900	1	
19	Лаборатори (Барилгын материалын)	м <sup>2</sup>	1200	1	



2.2 Агуулах, хадгалалтын бүс					
20	Химийн болон тэсэрч дэлбэрэх бодис хадгалах агуулах	м <sup>2</sup>	1800	1	Хувийн хөрөнгө оруулалт
21	Хүнсний бүтээгдэхүүний агуулах	м <sup>2</sup>	1800	2	
22	Хөргөлттэй агуулах	м <sup>2</sup>	1800	2	
23	Дулаан агуулах	м <sup>2</sup>	1800	4	
2.3 Ачаа тээвэр, терминалын бүс					
24	Том оврын техник хэрэгслийн агуулах	м <sup>2</sup>	1800	2	Хувийн хөрөнгө оруулалт
25	Задгай агуулах	м <sup>2</sup>	1800	2	
2.4 Бизнесийн төв					
26	Бизнес мэдээлэл сурталчилгаа, үйлчилгээний төв	м <sup>2</sup>	1800	1	Хувийн хөрөнгө оруулалт
27	Зочид буудал	м <sup>2</sup>	4000	1	
28	Үзэсгэлэн худалдаа	м <sup>2</sup>	4000	1	
29	Оффис	м <sup>2</sup>	2500	1	
30	Агуулах	м <sup>2</sup>	1800	3	
31	Жижиг дунд үйлдвэрийн барилга, байгууламж	м <sup>2</sup>	500	3	
32	Хог ангилан, анхан шатны боловсруулалт хийх байгууламж	м <sup>2</sup>	500	1	
3. Суурьшлын бүс					
33	Доороо үйлчилгээтэй нийтийн орон сууц	м <sup>2</sup>	2200	15	Улсын төсөв, Хувийн хөрөнгө оруулалт
34	Эдэлбэр газартай амины орон сууц	м <sup>2</sup>	384	25	
35	Эдэлбэр газаргүй амины орон сууц	м <sup>2</sup>	340	20	
36	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (280 суудалтай)	м <sup>2</sup>	1900	1	Улсын төсөв
37	Цэцэрлэг (75 хүүхдийн)	м <sup>2</sup>	364	1	
38	Эрүүл мэндийн төв (10 ортой)	м <sup>2</sup>	585	1	
39	Соёл, спортын цогцолбор (240 суудал)	м <sup>2</sup>	1500	1	
40	Засаг захиргааны барилга	м <sup>2</sup>	700	1	
41	Худалдаа, үйлчилгээний төв (банк, холбооны салбартай)	м <sup>2</sup>	1000	1	Хувийн хөрөнгө оруулалт
42	Оффис	м <sup>2</sup>	4000	1	
43	Цагдаагийн хэсэг	м <sup>2</sup>	190	1	Улсын төсөв



Зам талбай, ногоон байгууламж				
1	Хорооллын чанартай төв зам (өргөн10-12м)	км	5	Орон нутгийн төсөв
2	Хороолол доторх зам (өргөн 5-7.5 м)	км	8	
3	Амралт, спорт, явган хүний зам талбай	мян.м <sup>2</sup>	40	
4	Нийтийн хэрэгцээний ногоон байгууламж	мян.м <sup>2</sup>	24	
5	Тусгай зориулалтын ногоон байгууламж	мян.м <sup>2</sup>	10	
Инженерийн дэд бүтэц				
д.д	Инженерийн хангамж	Эх үүсвэр, шугам сүлжээний нэр, хүчин чадал	тоо, хэмжээ	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	Цахилгаан хангамж	дэд станц (35/10кВ)	2	Улсын төсөв
		ЦДАШ (35кВ) (км)	10	
		зуух (1МВт)	4	
2	Дулаан хангамж	гол шугам (ф273) (км)	5	
		хэрэгцээний халуун усны шугам (ф133x2) (км)	2.5	
3	Ус хангамж	усан сан (м.куб/хоног)	220	
		гүний худаг	2	
		гол шугам (ф200) (км)	5	
4	Ариутгах татуурга	цэвэрлэх байгууламж (м.куб/хоног)	350	
		өргөлтийн насос станц	2	
		гол шугам (ф150)	5	
5	Холбоо	АТС	1	
		АТС-ын шугам сүлжээ	15	
Боомтын нэвтрүүлэх хүчин чадал				
Зорчигч, ачаа тээврийн боомт	Үзүүлэлт		Хэмжээ	
	Зорчигч (хүн/хоног)		1200	
	Суудлын автомашин (машин/хоног)		200	
	Том оврын тээврийн хэрэгсэл (машин/хоног)		100	
Уул уурхайн бүтээгдэхүүн, зорчигч, ачаа тээврийн боомт	Зорчигч (хүн/хоног)		1200	
	Суудлын автомашин (машин/хоног)		100	
	Том оврын тээврийн хэрэгсэл (машин/хоног)		200	



Засгийн газрын 2014 оны 8 дугаар тогтоолын  
1 дүгээр хавсралтын 3 дугаар хэсэг

III. Хоёр талын зорчигч, ачаа тээврийн, түр ажиллагаатай боомтууд					
д.д	Барилга, байгууламжийн нэр	Хүчин чадал		Барилга, байгууламжийн тоо	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
		хэмжих нэгж	хэмжээ		
1. Хяналт шалгалтын бүс					
1.1 Авто замын шалган нэвтрүүлэх бүсийн барилга, байгууламж					
1	Хилийн хаалга	м	20	1	Улсын төсөв
2	Хилийн шалганы байр	м <sup>2</sup>	36	2	
3	Шалган нэвтрүүлэх цогцолбор (доороо гражтай)	м <sup>2</sup>	1200	1	
4	Түр саатуулах машины граж	м <sup>2</sup>	72	1	
5	Авто пүү	тн	150	2	
6	Эрэлч нохойн байр	м <sup>2</sup>	100	1	
7	Мал, амьтанд эрүүл мэндийн үзлэг хийх байр	м <sup>2</sup>	45	1	
8	Хяналтын цамхаг	өндөр		1	
9	Нийтийн бие засах газар	м <sup>2</sup>	9.6	2	Орон нутгийн төсөв
1.1.1 Хилийн цэргийн албаны барилга, байгууламж					
10	Шалган нэвтрүүлэх заставын албаны байр	м <sup>2</sup>	50	1	Улсын төсөв
11	Гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчдын байр	м <sup>2</sup>	300	1	
12	Автомашинны граж	м <sup>2</sup>	18	2	
13	Агуулах	м <sup>2</sup>	162	1	
14	Албаны зочид буудал	м <sup>2</sup>	180	1	
15	Жижүүр харуулын байр	м <sup>2</sup>	18	1	
2. Логистикийн бүс					
2.1 Гаалийн хяналтын бүс					
16	Гаалийн хяналтын албаны байр	м <sup>2</sup>	1000	1	Хувийн хөрөнгө оруулалт



2.2 Агуулах, хадгалалтын бүс					
17	Химийн болон тэсэрч дэлбэрэх бодис хадгалах агуулах	м <sup>2</sup>	1800	1	Хувийн хөрөнгө оруулалт
18	Хүнсний бүтээгдэхүүний агуулах	м <sup>2</sup>	1800	1	
19	Хөргөлттэй агуулах	м <sup>2</sup>	1800	1	
20	Дулаан агуулах	м <sup>2</sup>	1800	1	
2.4 Бизнесийн төв					
21	Бизнес мэдээлэл сурталчилгаа, үйлчилгээний төв	м <sup>2</sup>	1440	1	Хувийн хөрөнгө оруулалт
22	Зочид буудал	м <sup>2</sup>	1300	1	
23	Оффис	м <sup>2</sup>	1600	1	
24	Агуулах	м <sup>2</sup>	1800	1	
3. Суурьшлын бүс					
25	Доороо үйлчилгээтэй нийтийн орон сууц	м <sup>2</sup>	2200	4	Улсын төсөв, Хувийн хөрөнгө оруулалт
26	Эдэлбэр газартай амины орон сууц	м <sup>2</sup>	384	8	
27	Эдэлбэр газаргүй амины орон сууц	м <sup>2</sup>	340	10	
28	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /280 суудалтай/	м <sup>2</sup>	1900	1	Улсын төсөв
29	Өрхийн эрүүл мэндийн төв	м <sup>2</sup>	270	1	Улсын төсөв
30	Засаг захиргааны барилга	м <sup>2</sup>	162	1	Улсын төсөв
31	Худалдаа, үйлчилгээний төв /банк, холбооны салбартай/	м <sup>2</sup>	400	1	Хувийн хөрөнгө оруулалт
32	Оффис	м <sup>2</sup>	600	1	
33	Цагдаагийн хэсэг	м <sup>2</sup>	64	1	Улсын төсөв
Зам талбай, ногоон байгууламж					
1	Хорооллын чанартай төв зам (өргөн 10-12м)	км	2		Орон нутгийн төсөв
2	Хороолол доторх зам (өргөн 5-7.5 м)	км	3		
3	Амралт, спорт, явган хүний зам талбай	мян. м <sup>2</sup>	15		
4	Нийтийн хэрэгцээний ногоон байгууламж	мян. м <sup>2</sup>	12		



Инженерийн дэд бүтэц				
Д.д	Инженерийн хангамж	Эх үүсвэр, шугам сүлжээний нэр, хүчин чадал	тоо, хэмжээ	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	Цахилгаан хангамж	дэд станц 10/0.4кВ	1	Улсын төсөв
		ЦДАШ (35кВ) (км)	5	
2	Дулаан хангамж	зуух (1МВт)	2	
		гол шугам (ф219) (км)	1.6	
		хэрэгцээний халуун усны шугам (ф103х2) (км)	1.6	
3	Ус хангамж	усан сан (м.куб/хоног)	120	
		гүний худаг	1	
		гол шугам (ф100) (км)	2	
4	Ариутгах татуурга	цэвэрлэх байгууламж (м.куб/хоног)	150	
		өргөлтийн насос станц	2	
		гол шугам (ф150)	1.5	
5	Холбоо	АТС	1	
		АТС-ын шугам сүлжээ	10	
Боомтын нэвтрүүлэх хүчин чадал				
Зорчигч, ачаа тээврийн боомт	Үзүүлэлт		Хэмжээ	
	Зорчигч (хүн/хоног)		200	
	Суудлын автомашин (машин/хоног)		30	
	Том оврын тээврийн хэрэгсэл (машин/хоног)		10	
Уул уурхайн бүтээгдэхүүн, зорчигч, ачаа тээврийн боомт	Зорчигч (хүн/хоног)		200	
	Суудлын автомашин (машин/хоног)		30	
	Том оврын тээврийн хэрэгсэл (машин/хоног)		60	



Засгийн газрын 2014 оны 8 дугаар тогтоолын  
1 дүгээр хавсралтын 4 дүгээр хэсэг

IV. Дамжин өнгөрөх зориулалттай түр ажиллагаатай хоёр талын авто замын боомтууд					
д.д	Барилга, байгууламжийн нэр	Хүчин чадал		Барилга, байгууламжийн тоо	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
		хэмжих нэгж	хэмжээ		
1. Хяналт шалгалтын бүс					
1.1 Авто замын шалган нэвтрүүлэх бүсийн барилга, байгууламж					
1	Хилийн хаалга	м	20	1	Улсын төсөв
2	Хилийн шалганы байр	м <sup>2</sup>	36	2	
3	Шалган нэвтрүүлэх цогцолбор /доороо гражтай/	м <sup>2</sup>	1000	1	
4	Түр саатуулах машины граж	м <sup>2</sup>	36	1	
5	Авто пүү	тн	150	2	
6	Эрэлч нохойн байр	м <sup>2</sup>	50	1	
7	Мал, амьтанд эрүүл мэндийн үзлэг хийх байр	м <sup>2</sup>	45	1	
8	Хяналтын цамхаг	өндөр	стандарт	1	
9	Нийтийн бие засах газар	м <sup>2</sup>	9.6	1	Орон нутгийн төсөв
1.1.1 Хилийн цэргийн албаны барилга, байгууламж					
10	Шалган нэвтрүүлэх заставын албаны байр	м <sup>2</sup>	50	1	Улсын төсөв
11	Гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчдын байр	м <sup>2</sup>	300	1	
12	Автомашинны граж	м <sup>2</sup>	18	2	
13	Агуулах	м <sup>2</sup>	72	1	
14	Албаны зочид буудал	м <sup>2</sup>	180	1	
15	Жижүүр харуулын байр	м <sup>2</sup>	18	1	





3. Суурьшлын бүс					
16	Эдэлбэр газартай амины орон сууц	м <sup>2</sup>	384	12	Улсын төсөв, Хувийн хөрөнгө оруулалт
17	Эмийн сан /эмч/	м <sup>2</sup>	150	1	Улсын төсөв
18	Ахуй үйлчилгээ, дэлгүүр	м <sup>2</sup>	300	1	Хувийн хөрөнгө оруулалт
Зам талбай, ногоон байгууламж					
1	Хороолол доторх зам (өргөн 5-7.5 м)	км	0.5		Орон нутгийн төсөв
2	Амралт, спорт, явган хүний зам талбай	мян. м <sup>2</sup>	3		
3	Нийтийн хэрэгцээний ногоон байгууламж	мян. м <sup>2</sup>	0.3		
Инженерийн дэд бүтэц					
Д.д	Инженерийн хангамж	Эх үүсвэр, шугам сүлжээний нэр, хүчин чадал		тоо, хэмжээ	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	Цахилгаан хангамж	дэд станц 10/0.4кВ		1	Улсын төсөв
		ЦДАШ (10кВ) (км)		4	
2	Дулаан хангамж	зуух (1МВт)		2	
		гол шугам (ф219) (км)		1	
		хэрэгцээний халуун усны шугам (ф103х2) (км)		1.2	
3	Ус хангамж	усан сан (м.куб/хоног)		75	
		гүний худаг		1	
		гол шугам (ф100) (км)		1	



4	Ариутгах татуурга	цэвэрлэх байгууламж (м.куб/хоног)	100	
		өргөлтийн насос станц	1	
		гол шугам (ф150)	1.5	
5	Холбоо	АТС	1	
		АТС-ын шугам сүлжээ	5	
Боомтын нэвтрүүлэх хүчин чадал				
Зорчигч, ачаа тээврийн боомт	Үзүүлэлт		Хэмжээ	
	Зорчигч (хүн/хоног)		100	
	Суудлын автомашин (машин/хоног)		15	
	Том оврын тээврийн хэрэгсэл (машин/хоног)		5	
Засгийн газрын 2014 оны 8 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт				
<b>БООМТЫН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ДАВТАН ХЭРЭГЛЭХ ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b>				
д.д	Барилга, байгууламжийн нэр	Хүчин чадал		Зургийн тоо
		хэмжих нэгж	өжжмөх	
Хяналт шалгалтын бүс				
Авто замын шалган нэвтрүүлэх бүсийн барилга, байгууламж				
1	Хилийн хаалга	м	10	1
2	Хилийн хаалга	м	20	1



3	Хилийн шалганы байр	м2	36	1
4	Шалган нэвтрүүлэх цогцолбор (доороо гражтай)	м2	2300	1
5	Шалган нэвтрүүлэх цогцолбор (доороо гражтай)	м2	1800	1
6	Шалган нэвтрүүлэх цогцолбор (доороо гражтай)	м2	1200	1
7	Шалган нэвтрүүлэх цогцолбор (доороо гражтай)	м2	1000	1
8	Түр саатуулах машины граж	м2	72	1
9	Түр саатуулах машины граж	м2	36	1
10	Эрэлч нохойн байр	м2	100	1
11	Эрэлч нохойн байр	м2	50	1
12	Мал, амьтанд эрүүл мэндийн үзлэг хийх байр	м2	45	1
13	Хяналтын цамхаг	өндөр	стандарт	1
Хилийн цэргийн албаны барилга, байгууламж				
14	Шалган нэвтрүүлэх заставын албаны байр	м2	50	1
15	Гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчдын байр	м2	350	1
16	Автомашинны граж	м2	18	1
17	Агуулах	м2	216	1
18	Албаны зочид буудал	м2	360	1
19	Албаны зочид буудал	м2	180	1
20	Жижүүр харуулын байр	м2	18	1
Төмөр замын шалган нэвтрүүлэх бүсийн барилга, байгууламж				
21	Төмөр замын шалган нэвтрүүлэх цогцолбор	м2	3450	1
Дүн				21



Суурьшлын бүс				
22	Доороо үйлчилгээтэй нийтийн орон сууц	м2	2200	1
23	Эдэлбэр газартай амины орон сууц	м2	384	1
24	Эдэлбэр газаргүй амины орон сууц	м2	340	1
25	Засаг захиргааны барилга	м2	700	1
26	Засаг захиргааны барилга	м2	162	1
Дүн				5
НИЙТ ДҮН				26

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.25

Индекс: 14003